



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 664

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдан авах,
үнийн дээд хязгаарыг тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны албан хэрэгцээнд зориулан 1 ширхэг автомашиныг 111,100,000.00 (нэг зуун арван нэгэн сая нэг зуун мянган) төгрөгт багтаан худалдан авахыг зөвшөөрч, техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Эрчим хүчний зохицуулах хорооны ажлын албаны дарга Г.Эрхэмбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын дагуу худалдан авсан хөрөнгийг бүртгэлд тусгах ажилд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА 
Б.ЦЭНГЭЛ
ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

13201450

D:\Huraldaanii material\2020 on\2020.12.08 19r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн
66.4 дугаар тогтоолын хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН
ҮЗҮҮЛЭЛТ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ (төгрөг)	Худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг)
1	Автомашин, микро автобус, 2400cc-2500cc	ш	1	111,000,000.0	111,000,000.0
НИЙТ ДҮН					111,000,000.0 (нэг зуун арван нэгэн сая нэг зуун мянган)